

Орон бүхний пролетариат нар нэгдэгч! АНХ ДУГААР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.ДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь
жилдээ

№ 73 (2377)

1974 оны 9 дүгээр сарын 30

ДАВАА

ОЙН ШИНЭ ХУУЛЬ

Манай нийгэм эдийн засгийн хөгжил, социалист байгуулалтын өнөөгийн шаардлагаас үндэслэж ойн хуулийг шинэчлэн улам боловсронгуй болгох асуудал урган гарсантай холбогдуулан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид 1974 оны 7 дугаар сарын 1-нд ойн шинэ хуулийг батлан гаргасан билээ.

Уг хуулинд тус улсын нутаг дэвсгэр дээр ой, түүний байлгийг зохиотой ашиглах, арчилан хамгаалах, өсгөж үржүүлэх ажлыг зохион байгуулах асуудлыг хуульчлан заажээ.

Ойн энэ хуулиар гал түймрээс урьдчилан сэргийлэх, түймрийг шуурхай унтраах явдал улс хоршоолол, олон нийтийн байгууллага, иргэдийн үүрэг мөнийг заасан нь албан үйлдвэрийн газар, хүн бүр байгаль ой модыг хамгаалах талаар хичнээн өндөр хариуцлага хүлээж байдгийг улам тодруулав.

Ой хүний эрүүл мэндэд болон байгаль орчныг гоо үзэсгэлэнтэй сайхан болгох, хөрс хамгаалах, усны горим, хур тунадасны хэвийн байдалд хичнээн чухал үүрэг гүйцэтгэдгийг онцлон анхаарч хот суурин болон эмнэлэг, амралт сувилалын газар, рашаан, булаг шандны эх орчим, гол мөрөн, нуурын эрэг, авто машин, төмөр замын дагуу ногоон бүс, хамгаалалтын зурвас ой үлдээх хэмжээг нэмэгдүүлсэн байна.

Төгөл нэг нэгнээсээ алслагдсан бага хэмжээтэй ба уулын хяр хэт их налуу газрын ой болон их ойг ч гэсэн захиас нь эхлэн огтлож ашиглахыг хориглож өсвөрийн болон таримал ой, хайлаас, яшил, тоорой, яргай, сухай зэрэг ховор мод, чацаргана мэт жимст ховор бут сөөгийг огтлож хугалж гэмтээхийг хуулиар хамгаалав.

Манай оронд их биш хэмжээгээр ургадаг улс ардын аж ахуй, үйлдвэрийн чухал ач холбогдолтой хуш нарсыг барилга үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулан бэлтгэх зөвшөөрлийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл олгодог болсон явдал тэдгээрийн нөөцийг арчилан хамгаалж ариг гамтай ашиглах нөхцлийг бүрдүүлж өглөө. Түвшинд модны гишүү мөчир, үзүүр ёзоорыг ашиглах, элдэв хортой шавьж, өвчин, гал түймэрт нэрвэгдэж цаашид ургахгүй болсон буюу өтөлж хөгшрөөд барилга үйлдвэрлэлийн хэрэгцээнд тохирогүй болсон модыг ойгоос цуглуулах журмаар бэлтгэх болсон нь ойн байлгийн ашигдалтыг сайжруулж нэгж талбай, нэг модноос гарах хэрэгцээт хэсгийн хэмжээг нэмэгдүүлэхийг холбогдох байгууллага, хүмүүсийн өмнө чухал зорилт болгон тавилаа.

Мод бэлтгэгч байгууллага иргэдийн үүргийг тодорхой болгохын зэрэгцээ тэдэнд ойн хууль тогтоомжийг элдвээр зөрчиж байгааг илрүүлж мэдээлэх, түүнтэй тэмцэх хариуцлагыг хүлээлгэх болсон байна.

Ойн хууль тогтоомж зөрчигчдэд хүлээлгэх харуцлагыг нарийвчлан зааж ойн аж ахуй, ойн анги, тэдгээрийн ажилтан, албан хаагчдын гүйцэтгэх үүргийг улам тодорхой болголоо.

Ойн шинэ хууль бол ойг арчилан хамгаалах, өсгөн үржүүлэх ажлын эрч далайц үр дүнг нэмэгдүүлэх, ой хамгаалалтыг журамтай болгох, тэдгээр ажлыг эрхэлсэн байгууллага, иргэдийн ажлын хариуцлагыг сайжруулах зорилгоор нам, засгаас авч байгаа чухал арга хэмжээ юм.

Иймээс ой болон хуулийн төв, орон нутгийн байгууллага ойн шинэ хуулийн утга агуулга, ялангуяа түүний байгаль хамгаалах ач холбогдол, мөн ойн байлгийг ашиглах, хамгаалах, өсгөн үржүүлэх чиглэлээр албан байгууллага иргэд ямар эрх эдэлж, улс нийгмийн өмнө ямар үүрэгтэй ажиллах талаар сурталчлах ажлыг тодорхой дэс дараатай зохиох нь чухал юм. Ойн хуулийг биелүүлэхэд албан байгууллага, ард иргэдээс гадна ойн ажлыг эрхэлж байгаа байгууллага, тэдгээрийн ой хамгаалагч нар онцгой үүрэг гүйцэтгэж, гарсан зөрчлийг тухай бүрт нь илрүүлэн засч, байхын хамт албан байгууллага, иргэн бүр ойн шинэ хуулийг нарийн чанд биелүүлэх явдал чухал байна.

УРГАЦ ХУРААЛТ

Баянцогтын САА-н хэмжээгээр 9 дүгээр сарын 21-ний байдлаар 8600 га талбайгаас 9600 гаруй тонн ургац хурааж ургац хураалтаа 10 дугаар сарын 1-ний дотор дуусгах зорилт тавин ажиллаж байгаагийн дотор 1,4,5-р бригадууд бусдаасаа давуу амжилттай байна.

БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат, комбайнч Д. Очир өдөрт 41 га тал байн ургац хурааж САА-д рекорт амжилт гаргав.

Мөн 1 дүгээр бригадын Маам, Цэрэндаш, Төлөвхаан, 3 дугаар бригадын Будёнин, 2 дугаар бригадын Наянтай, Шийтэр 6 дугаар бригадын Пунцаг, Нямдорж нар өдөр бүрийн ургац хураалтын төлөвлөгөөг 110—200 хувь биелүүлжээ.

Б.ОЧИРБАТ




Ойн аж ахуйн модон эдлэлийн товийн тасгийн мужаан Н. Идамсүрэн V таван жилийн төлөвлөгөөг 1 жил 6 сарын өмнө 100,7 хувиар биелүүлж V таван жилийн гавиштай тэмдэг сахлан авсан юм.

Зураг дээр:

Мужаан Н. Идамсүрэн мод зорогч машин дээр ажиллаж байна.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ-ийн авсан гэрэл зураг



Нийслэл хотын 50 жилийн ойн өмнө

Улаанбаатарчууд их ойгоо угтаж...

МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50, Улаанбаатар хотын 50 жилийн түүхт ойнуудыг нийслэлийнхэн маань хөдөлмөр бүтээлийн их амжилтаар угтаж байна.

Бүх ард түмний социалист уралдаан өрнүүлэх тухай МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөл МҮЭ-ийн Төв Зөвлөл, МХЗЭ-ийн Төв Хорооны тогтоолыг өнгөрсөн онд нийслэлийнхэн баяртай хүлээн авч үйлдвэр аж ахуй, соёлын бүхий л салбараа социалист уралдааныг эрчимтэй өрнүүлжээ. Нийслэлийн үйлдвэр аж ахуй, соёл, үйлчилгээний байгууллага 1973 онд өндөр бүтээлийн уралдаан 800, сэдэвт уралдаан 600 гаруй, шинэ санаачлагын уралдаан 100 шахам удаа зарлаж шалгарсандад 24 сая төгрөгийн шагналыг олгосон байна.

БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат нийслэлийн иргэн, алдарт нэхмэлчин Б. Гүнжиламын туршлагаар тус хотын 6000 гаруй хүн үүрэг амлалт авч ажиллаж сайхан амжилт олжээ.

Барилга угсралтын ажилд аж ахуйн тооцоо нэвтрүүлж байгаа нэгдсэн бригадын дарга Ардын Их Хурлын депутат С.Хэр

лэн, саятны бригадын ахлагч, хөдөлмөрийн баатар Л. Самбуу-ёндон, хөдөлмөрийн баатар, уурхайчин А. Орногвайн хоногийн нэгдсэн бригадын туршлагаар 287 тасаг, цех, бригад үүрэг авч 95 хувь нь авсан үүргээ амжилттай биелүүлсэн байна.

Энэ бүхний дүнд нийслэл хотын аж үйлдвэрийн төлөвлөгөөг хугацаанаас нь гурав хоногийн өмнө биелүүлж 20,7 сая төгрөгийн бүтээгдэхүүн илүү үйлдвэрлэжээ.

Тавин жилийнхээ ойг тэмдэглэх жил-1974 оны уралдаанд үүрэг авсан нийслэлийн байгууллага, хүмүүсийн тоо урьд оныхоос 10,5—11,2 хувь өсчээ. Улаанбаатарчууд энэ онд жилийн үйлдвэрийн төлөвлөгөөг хугацаанаас нь 4 хоногийн өмнө биелүүлж төлөвлөгөөг 20,0 сая төгрөгөөр давуулж нийслэлийн хэмжээгээр 25 сая төгрөгийн нэмэгдэл хуримтлал оруулах үүрэг авчээ.

Социалист уралдаан илгээр өрсөнөөр энэ оны бүтээн 8 сарын аж үйлдвэрийн төлөвлөгөөг 102,3 хувь биелүүлснийг урьд оны мөн үетэй харьцуулбал 8,1 хувь өсчээ.

Нийслэл хотоо тохижуулан цэцэрлэгжүүлэх ажил

урд урьдаас улам өрнөлтэй явагдаж өнөө жилийн хаврын өдрүүдэд нийтдээ 22,2 мянган ширхэг мод тарьж, 88,8 мянган ширхэг бут сөөг суулгаж, 85,8 мянган хавтгай дөрвөлжин метр газрыг шинээр буюу шинэчилж зүлэгжүүлжээ.

Эх орныхоо нийслэлийн 50 жилийн ойд зориулж 18 аймаг, Дархан хот амт чанар сайтай хүнсний бүтээгдэхүүн борлуулах 45 хоногийн ажлыг Улаанбаатар хотод 9 дүгээр сарын 17-ноос эхлэн зохиож байна.

Манай нийслэлийн соёл урлагийн зүтгэлтнүүд уран бүтээлчид их ойдоо шинэ зүйл олныг туурвиж байна. «Олондоо алдартай Улаанбаатар» гэсэн уран зохиолын ном, өнгөт баримтат богино хэмжээний кино хийгээд дуусч байна. Ойд зориулсан том концерт бэлтгэж нийслэлийн амьдралыг харуулсан олон сайхан урач зураг бүтээгдэж байна.

Эх орны нийслэлийн 50 жилийн ойд Москва, болон Берлин, Варшава, Прага зэрэг ах дүү орны алдар цуут нийслэл хотын төлөөлөгчид хүрэлцэн ирэх гэж байна.

Манай сурвалжлагч
Л. ГУНГААБУУ

ТАВАНЖИЛИЙН ГАВШГАЙЧ

МАХН-ЫН III ИХ ХУРАЛ ХУРАЛДСАНЫ БОЛОН БНМАУ-ЫГ ТУНХАГЛАСНЫ
50 ЖИЛИЙН ОЙД

БНМАУ-д бичиг үсэг үл мэдэх явдлыг устгасан нь

Ардын хувьсгалаас өмнө манай орны хүн ам бичиг үсэг мэдэхгүй харанхуй бүдүүлэг байсан нь тус орныг хөгжүүлэх, шинэ нийгэм байгуулах явцад үлэмжийн саад учруулж байв.

Хөгжлийн капиталист биш замыг сонгон авсан Монгол улс хүн амыг бичиг үсэгтэй болгох зорилтыг нэн тэргүүнд тавьсан юм.

Энэ зорилтыг шийдвэрлэхийн тулд манай нам засаг ардын хувьсгал ялсан анхны өдрөөс эхлэн олон чухал арга хэмжээ авч хэрэгжүүлсэн юм.

Ардын хувьсгал ялсан 1921 оноос эхлэн насанд хүрэгчдийг бичиг үсэгт сургах түр сургуулийг орон нутагт байгуулж улмаар 1924 оны 2 дугаар сард Ардын Гэгээрлийн Яамыг байгуулав.

Энэ үеэс буюу 1924—1934 онд ардын гэгээрлийн системийн үндсэн суурь ерөнхийдөө тавигдсан байна.

Ард олныг бичиг үсэгт сайтар сургахад өрдөм номтой багшлах боловсон хүчин ихээхэн шаардагдаж байлаа.

Үүнтэй уялдуулж 1922 оноос эхлэн багш нарыг бэлтгэх ба давтан сургах курс байгуулж үндэсний анхны багш нарыг бэлтгэн гаргадаг болжээ.

Бүр 1925 он гэхэд Ардын гэгээрлийн яаманд хөдөлмөрчдийг бичиг үсэгт сургах тусгай хэлтэс, хот хөдөөд сургуулийн наснаас хэтэрсэн залуучууд, ард иргэдийг бичиг үсэгт сургахын тул арван гэрийн сургууль,

төв суурин газруудад бичиг үсгийн бүлгэм байгуулж судар бичгийн хүрээлэнгээс насанд хүрэгчдийн анхны сурах бичгийг хэвлүүлж 1929 онд бага сургуулийн багш, багшийн сургуулийн сурагчид зэрэг 300 гаруй хүнийг 2 сарын хугацаагаар орон нутагт явуулж хөдөлмөрчдөд бичиг үсэг заалгах ажлыг зохион байгуулж байжээ.

МАХН-ын IX их хурал, БНМАУ-ын VII их хурлаас үндэсний соёл боловсролыг хөгжүүлэх тухай асуудлыг тусгайлан хэлэлцсэн чухал шийдвэр гаргасны дагуу 1934 онд нам, эвлэлийн байгууллага, албан үйлдвэрийн газрууд өөрсдийн албан хаагчдыг үндэсний бичиг үсэгт албан журмаар сургах журам тогтоожээ.

Үүний зэрэгцээгээр цэргийн алба хаасан залуучуудыг бичигтэн болгож улмаар тэднийг орон нутгийн ард түмэнд бичиг үсэг сургах ажилдаа дайчлан ажиллуулсан нь үр дүнгээ өгчээ.

Мөн бичиг үсгийн дугуйлан бүлгэмийн ажиллах заавар, дүрэм, бичиг үсэг суралцагчдад зориулсан цагаан толгой, унших дэвтрийг хэвлүүлж бичиг үсэг сургахад улсаас ихээхэн хөрөнгө зарсан байна.

Ардын багш нар бичиг үсгийн бүлгэм байгуулах, айл өрхөөр явж бичиг заах, хүмүүсийг шөфлөн авч бичигтэн болгох зорилгыг арга хэргээний үр дүнд бичиг мэдэгчдийн

тоо жилээс жилд нэмэгдсээр байв.

1924 онд шинэ үсгийн цагаан толгой, өврийн цагаан толгой зэрэг сурах бичиг, гарын авлага болсон зүйл хэвлэгдэн гарсан нь хөдөлмөрчдийг шинэ үсэгт сургахад ихээхэн дөхөм үзүүлж байлаа.

МАХН-ын Төв Хороо 1949 онд хөдөлмөрчдийг шинэ бичигт сургах ажлын явцын тухай авч хэлэлцээд бичигтэн бүрт 3-аас доошгүй хүнийг сургах үүрэг ноогдуулж, «өөрөө сураад бусдыг сурга» гэсэн уриан дор бичиг үсэгт сургах ажлыг улам өргөжүүлж энэ хөдөлгөөнийг орон даяар өрнүүлжээ.

Энэ бүхний үр дүнд 1963 он болоход бичиг үсэг үл мэдэх явдал үндсэндээ устсан байна.

Бүх нийтээр бичиг үсэг үл мэдэх явдлыг ийнхүү амжилттай шийдвэрлэсэн нь тус орны хөдөлмөрчдийн соёлын болон ерөнхий боловсролын хэмжээг дээшлүүлэх нөхцлийг бүрдүүлсэн юм.

Ийнхүү ардын хувьсгал ялалад манай орны хүн амын зуугаас нэг нь дутуу бичигтэй, зургаагийн нэг нь дуганд олбогтой байсан бол одоо 13—49 насны бүх хүн ам бичигтэн болсны дээр бүх нийтийг бүрэн биш дунд боловсролтой болгох зорилт хэрэгжиж байна.

Энэ бүхэн бол манай нам төрөөс улс орноо капиталист биш замаар хөгжүүлэхэд соёлын хувьсгалын талаар авч явуулсан зөв мэргэн бодлогын бодит биелэл мөн.

Л. ГУНГААБУУ

БАТСҮМБЭР СУМЫН ХБ-ИЙН АНГИЙН ХАМТ ОЛНООС ГАРГАСАН УРИАЛГА

МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн түүхт бйнууд угтаж энэ оны худалдаа үйлчилгээний бүх төлөвлөгөөт зорилтуудыг тоо чанарын үзүүлэлтүүдээр хугацааны өмнө жигд давуулан биелүүлэх зорилгоор тус аймгийн нийт худалдаа бэлтгэлийн байгууллагуудыг социалист уралдаанд уриалж доорх үүргүүдийг авч байна.

ҮҮНД:
Худалдаа, бэлтгэлийн талаар

—1974 оны бараа, ном борлуулалтын төлөвлөгөөг 20 хоногийн өмнө 105—110 хувь, талх үйлдвэрлэн борлуулах төлөвлөгөөг 30 хоногийн өмнө 120-оос доошгүй хувиар биелүүлнэ.

—Амт чанар сайтай олон нэр төрлийн хоол, ундааны зүйлээр хөдөлмөрчдийг хөнгөн шуурхай үйлчилж жилийн нийтийн болон халуун хоолны төлөвлөгөөг 101—102 хувиар биелүүлнэ.

—Бүх төрлийн ноос, ноолуур, хөөвөр, хялгасны жилийн төлөвлөгөөг төрөл бүр дээр нь 101—135 хувиар биелүүлж 2-оос доошгүй тонн ноос давуулан тушаана.

—Түүхий эд бэлтгэлийн 47 нэр төрлийн төлөвлөгөөг чанарын өндөр үзүүлэлтээр 10 хоногийн өмнө 100—200 хувь биелүүлнэ.

Санхүү, цаг үеийн ажлын талаар
—Социалист өмч хөрөн-

гийг хамгаалан, өр авлагагүй хамт олон болж энэ оны ашгийн төлөвлөгөөг 120 хувиар биелүүлж хөдөлмөрийн бүтээмжийг 5-аас доошгүй хувиар нэмэгдүүлнэ.

—Анхан шатны бүртгэл тооцоог ажилдаа бүрэн нэвтрүүлж эд хариуцагчдын сар, улирал, жилийн тооллого тооцоог тогтмол чанартай явуулж, сар, улирал, жилийн тайланг тогтоосон хугацаанд нь чанар сайтай тушааж байхын хамт агент, худалдагчдын барааны хэмжээг нормативт нь тогтмол байглана.

—Гавьяат тогооч Дашзэвэг, Баянзүрх сумын ХБ-ийн ангийн агент аймгийн аварга Дожгоотов, Баянцогт сумын ХБ-ийн ангийн барааны нярав Жамц нарын туршлагаас ажилдаа нэвтрүүлнэ.

—Энэ жилийн өвлийн ба төлийн бэлтгэл хангах, тариа,ногоо, төмс хураалтын ажилд нийтээр зохион байгуулалттай ажиллана.

—Намрын төмс, хүнсний ногоо хураах штабуудын дэргэд гуанз 2-ыг байгуулан ажиллаж оюутан сурагчид, тээвэрчид, тариаланчдад амт чанар сайтай хоол ундаа бусад хэрэгцээт бараагаар тасралтгүй үйлчилнэ.

Тус аймгийн нийт ХБ-ийн байгууллагууд бидний нэгэн адил төлөвлөгөөг зорилтуудаа хугацааны нь өмнө давуулан биелүүлнэ гэдэгт итгэж байна.

БАТСҮМБЭР СУМЫН СХ-ИЙН ТӨЛӨӨ ХБ-ИЙН
АНГИЙН ХАМТ ОЛОН

ТАВАН ЖИЛИЙН ГАВШГАЙЧ

МАХН-ын XVI их хурлын түүхт шийдвэр, улс ардын аж ахуй соёлыг хөгжүүлэх V таван жилийн төлөвлөгөөт зорилтыг хугацаанд нь амжилттай биелүүлэхийн тулд тус аймгийн ХАА, үйлдвэр, барилга, тээвэр холбоо, соёл гэгээрэл, худалдаа, үйлчилгээ, эрүүлийг хамгаалах зэрэг бүхий л салбарт социалист уралдаанд эрчимтэй өрнөж байна.

Үйлдвэрийн газрын ажилтан ажилчид социалист уралдаанд тооцоотой үүрэг амлалт авах, бүтээлч төлөвлөгөөтэй ажиллах явдал өнгөрсөн онд бүх нийтийн үйлс болон эрчимжиж сайхан амжилт олсон билээ.

V таван жилийн төлөвлөгөөний шийдвэрлэгч жил—1974 онд МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ой угтсан бүх ард түмний со-

циалист уралдаанд үүрэг авч ажиллаад хөдөлмөрийн өндөр амжилт гаргаж байгаа сум—нэгдэл, САА, ТАА, үйлдвэрийн газрын хамт олон, ажилчдын тоо өссөөр байна.

Одоо жил ба таван жилээр тооцоотой үүрэг авсан гавшгайчид 2000 шахам, үйлдвэрлэлийн хамт олон 3 ажиллаж байгаагийн дотор Батсүмбэрийн САА-н Пүрвээ даргатай ногоо бригад, БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат Х. Сэдэд даргатай саалийн 2 дугаар бригад таван жилийн төлөвлөгөөг тоо чанарын үзүүлэлтээр давуулан биелүүлэхээр үүрэг авч ажиллаад амласан үүргээ амжилттай биелүүлэх боломж олоод байна.

Таван жилийн төлөвлөгөөт зорилтоо хугацаанаас нь 2 жил 3 сараас 1 жил 6 сарын өмнө амжилттай биелүүлсэн САА, нэгдлүүд, аж үйлдвэр, ой,

барилга, тээвэр, холбоо, соёлын газруудын 140 гаруй ажилчин, малчин таван жилийн гавшгайч гэдэг эрхэм хүндэт цол хүртээд байна.

Эдний дотроос Угтаалын САА-н комбайнч БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Г. Алтанхүү эзэмшсэн СК—4 комбайнаар төлөвлөгөөт таван жилд шуудад шилжүүлснээр 1400 га-гийн ажил гүйцэтгэж 19600 центнер ургац цайруулах төлөвлөгөөт зорилтоо эхний 2 жил 3 сард 2759 га-гийн ажил гүйцэтгэж 29067 центнер ургац цайруулж амласан үүргээ 197 хувиар биелүүлжээ.

Батсүмбэрийн САА-н саальчин, БНМАУ-ын аварга малчин Ц. Хорлоо 5 жилийн төлөвлөгөөг хугацааны өмнө биелүүлэхээр тооцоотой үүрэг авч ажиллаад эхний 3 жилд 125,8 мянган литр сүү сааж амласан үүргээ 103,9 хувь,

БНМАУ-ын хошой аварга ногоочин Ж. Баатар таван жилд авах ургацын төлөвлөгөөг 2,2 дахин, НААУ-ний оёдлогчин Б. Дашцэрмаа 2 жил 5 сарын өмнө 122,6 хувь, Зам ашиглалтын ангийн мужаан Д. Содном 105,5 хувь, Борнуурын САА-н саальчин Н. Дэжид 3 жилийн өмнө сүүний төлөвлөгөөг 114,2 хувиар тус тус биелүүлээд байна.

Гэвч тус аймгийн хэмжээнд ажилчдаар болон хамт олноор тооцоотой үүрэг амлалт авахуулах, авсан үүргийн биелэлтийг хүн нэг бүрээр нарийн тооцож дүгнэх ажлыг сум—нэгдэл, САА, үйлдвэр, аж ахуйн газруудын нам, захиргаа, УЗ-ийн байгууллагуудаас жигд сайн удирдахгүй байна.

Мөн тооцоотой үүрэг авч түүнийг биелүүлсэн тэргүүний хүмүүсийн туршлагыг нийтийн хүртээл болгох ажил хангагдгүй байна.

Ийм учраас жил ба таван жилээр үүрэг амлалт

авагчдын биелэлтийг жил, улирал, сараар тогтмол дүнгэж ажилчин, хамт олонд хугацаанд нь мэдээлж сурталчилж байх нь чухал. Таван жилийн гавшгайч нэг бүр үлдэж байгаа хугацаанд хийх ажлын талаар уралдааны гэрээ байгуулж, гэрээний хээ дүнг сар сараар гаргаж ажиллалалд зохино.

У таван жилийн төлөвлөгөөг хугацааны нь өмнө биелүүлсэн тэргүүний ажилтан ажилчдын санаачлага туршлагыг нийтэт сурталчилж ажлын чанаржуулах хэрэгтэй байна.

МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн түүхт ойн наана жилийн буюу таван жилийн төлөвлөгөөг биелүүлж хөдөлмөрийн бахдам амжилт гаргах нь сум—нэгдэл, САА, ТАА, үйлдвэр аж ахуйн газар, тэдгээрийн ажилчид, тариаланчид, нийт хөдөлмөрчдийн эрхэм чухал зорилт болж байна.

Д. АМАРЖАРГАЛ

АРДЫН ХЯНАЛТЫН НУУР

ХУРИ, ХАРАА

№ 3 (33)

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮР ДҮН

Баянцогтын САА-н АХ ШГ, ургац хураалтын үеийн хаягдалтай тэмцэх ажлыг олон хэлбэрээр зохиож байна.

Ургац хураалтын эхний 5 хоногийн ажлын явцад аж ахуйн ахлах мэргэжилтэнүүдийн оролцоотой хянан шалгах пост ажиллуулсан агрегат, автомашин, тээврийн зам, үтрэмийн ажиллагааг шалгаж. Хяналт шалгалтын ажил хянагчтай байгууллагуудын хүчийг чиглүүлж өндөр настан, ахмадууд, депутат зэргийг оролцуулан тэднийг бригад бүрт түр пост болгон зохион байгуулан ажиллуулж ургац хураалтанд ажиллаж байгаа комбайн бүрийн цайруулах мөрийг заан өгч ажлын явцыг шалгаж ажил

дуусмагц талбайг комбайн чаас хүлээн авч, хаягдлыг дор бүр нь авахуулах ажлыг цаг алдалгүй хийж байгаа нь үр дүнтэй арга хэмжээ болжээ. Тус САА-н АХШ групп Гунын 1,3 дугаар бригадын тариа-халдлт, цайруулалтанд шалгалт хийж 405 га-гийн талбайд ангиалт хийж байсан комбайнч Батжаргал, Пүрэвдорж нарын хэт дээгүүр хадаж комбайны хурд хэтрүүлж яснаас дэл далан үлдээсэн мөн цайруулалт хийсэн талбайд 16 балл авалгүй орхисныг илрүүлж дахин хураалгасан байна.

Мөн комбайны тохируулгыг комбайн бүр дээр шалгахад комбайнч Дугар, Бадарч нар комбайны цэвэр бохир будааны

шнөкт чигжээс хийгээгүйгээс будаа гоожих, мөн нялалж байгаа зэрэг зөрчлийг илрүүлжээ. Тус шалгах группийнхэн шалгалтынхаа дүнг «Дохно» сонин, мэдээлэх салбарт тавьж сурталчилж байна.

Мөн үр тариа хураалтанд ажиллаж байгаа комбайнчаас өдрийн нормоо биелүүлээгүй техникчидтэй тооцоо хийж, шалтгааныг илрүүлэн дараа өдөрт нь нөхөн биелүүлэх арга хэмжээ авч ажилласны дүнд ургац хураалтын ажлын явц бусад аж ахуйнуудаас ахицтай байна.

Ардын хянан шалгах групп, хураалтын явцад хяналт шалгалт хийсэн талбай бүрийг тусгай зурагт тэмдэглэж, бригадуудын ургацын талбайд ажиллаж буй хяналтын постууд ажлыг үе үе дүгнэж байна.

АХШГ тариа хураалтын үеэр шалгах группийг 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр гарган ажиллуулжээ. Саяхан тариа тээвэрлэлтэд шалгалт хийж машины

төвшний чигжээс дутуу хийгдсэнээс будаа хаягдаж байсныг засуулсны дээр комбайны тохируулгуудыг шалгаж цайруулалтанд орж болох тухай гэрчилгээ олгож, шалгалтын дүнг тусгай самбарт тавьж, бригад салаануудаар аялуулан сурталчилж байна. АХШГ-ийн товчооны хурлыг газар дээр нь хийж тасгуудын АХШ постуудыг хооронд нь харилцан солилцуулж ажлыг нь шалгуулж байгаа нь үр дүнтэй ажил болжээ.

Батсүмбэрийн САА-н АХШГ, пост, штабаас Сөгнөгөр, Баянгол, Үдлэгийн ногооны бригадуудын төмс, хүнсний ногооны талбайн зэрлэг зулгаалгах ажлыг хийлгэжээ. Анхны удаа 60 га-гийн зэрлэг зулгаахад 1000 гаруй хүнийг хамруулжээ. Мөн төмсийн штабууд дээр түр бүрдээ 6 хүний бүрэлдэхүүнтэй хяналтын түр пост ажиллуулж байна. Саяхан энэ постоос үтрэм талбайн хоорондох будаа тээвэрлэлт, төмс хураал-

тад шалгалт хийж, төмсийн хаягдалтай газар туг хатган, тэмдэг тавьж комбайнаар хураалгасны үр дүнд 10 тонн төмс дахин хурааж тушаав.

Борнуурын САА-н АХШГ төмс хураалтын эхний 7 хоногийн ажилд шалгалт хийж 15 тонн төмс хаягдсаныг илрүүлж дахин хураалгав. Тус группээс төмс, хүнсний ногоо хураалтын өдөр бүрийн ажлын дүнг орой нь радио үе дээр нэвтрүүлж ханын сонингоор тогтмол мэдээлж байгаа нь үр дүнгээ өгч байна.

Заамар сумын АХШХ-ээс 14 га газрын төмсийн хураалтанд хяналтын шалгалт явуулж алгасч орхисон бут, зэрлэг ургамалд хучигдаж үлдсэн мөрүүдийн ургацыг дахин хураалгаж 43 шуудай буюу 1310 кг төмс хаягдсаныг илрүүлж үүнийг 730 кг-ыг улсад тушаалгаж, 580 кг-ыг нь нэгдлийн дотоод хэрэг цээ, үрийн нөөцөнд шилжүүлжээ. Л. ГУНГАБУУ Д. ЭРХЭМБАЯР

НЭГЭН ИХ ЗАСВАРЫН ТҮҮХ

Саяхан НААУ-ний Газрын дарга Нацагдоржтой уулзаж барилга засварын ажлыг сонирхоход «Барилга засвар» бол өвлийн бэлтгэлийн салшгүй нэг хэсэг. Энэ жил зөвхөн 36 айлын сууцны их засвар 83568 төгрөг үүнээс засварчдын хөлсөнд 44700 төгрөг төсөвлөсөн юм.

Уул засварыг хийсэн барилгын техникч Балжинням, бригадын дарга Тунгалаг, манай орлогч дарга Лхагважав нар хэлэх нь засвар дууссан гэсэн гэлээ. Тэндээс барилгын техникч бөгөөд бригадын дарга Балжиннямыг дагуулж 36 айлын сууцны засварыг үзэхээр гарлаа.

Даргын өрөөнөөс гарахдаа Балжинням манайхан туршлагатай засварчид, энэ жилийн засварч гоц болсон гэсэнээ очих газраа орохын алдтай ер нь засвар дуусаад айлууд орсон, гэсэнч эргэж хармаар жаал зугаа юм үлдсэн гэж өгүүллээ.

Орлоор оруут нэг хүн шатны өнгөлгөө шавар хийж байв.

Түүнийг харсан Балжинням:

«Бид ордгий нь эхлэж янзлаад, орцы нь дараа болохоор шийдсэн юм. Засвар бол ерөнхийдөө дууссан, харин зарим нэг айл хэл ам татлаад байгаа. Тухайлбал нэг нөхөр ганц өрөөний шал будаагүйн төлөө их үг гаргаж байгаа».

Энэ мэтийг хийх болж байна гэх зэргээр ажлын хаа өнгийг таниулав.

Тэнд орон сууц эзэмшигчид уулзаж их засварын дутуу татууг үзүүлэхэд Балжинням дарга эхлээд сүрхий тайлбар хэлмээр байснаа сүүлдээ баахан бачимдаж дуугүй яв-

лаа.

—Ай юухан байхав, 10 хоногт дуусгачихана гэж амлаж гарсан засварчид 3 сар шахам ажиллахдаа улсын тэр их хөрөнгийг үрж хийсэн засварын түүх тун сонин. Анх бригадын дарга Тунгалаг, Балжинням хоёр, 20 засварчиндаа 8 мэргэжилтнээ «хүртээгээд» 6 дугаар сарын 15-нд зэрэг «дайралтаа» хийжээ. Хэд хоноод засварчдаа бүртгэсэн чинь нээрээ ч чадал нь хүрээгүй юм уу, нэр цэвэр гарья гэж бодсон ч юмуу зарим нь ирэхээргүй явчихжээ. Энэ хэрэг ер нь бишдэх нь гэж бодоод ажиллах хүч нэмсэнд 16 нас хүрээгүй хүүхдүүд дагалдангийн дагалдангаар ажиллах болжээ.

Барс будаг нийлүүлж, хадаас алх уулзуулахгүй хэн байхав.

Мэргэжил зэргэжил ч яамай гээд орчихсон чинь хананы шавардлагыг хадаасаар тогтоох аргагүй болохоор зарим нь аргаа барахдаа алгаараа дарчихаад хатахы нь хүлээсэн аж. Цонх шиллэхээр шил зүсэх болсонд бүгдээрээ чадна гээд «зэрэг дайралтаа» хийхдээ шил гэдгийг ширэмний дайтай бөхөд санаж ёстой нэг яйруулж өгчээ. Эцэст жавар салхи л хавчаа барж жаран зүйлэлтэй ч яамай байнаа гээд зүйж гарчээ.

Ийнхүү тэр өдөр авахаа тооцоолсноос биш хийхээ тооцоолоогүй гарсан их засварын бригадын хан байдаг шилээ хагачиж дуусаад багсаар будгаа хольж найруулаад эцсийн өрөөний хаалга цонхыг «эрийл» өнгөлөхөөс аргагүй болжээ.

Барилга засвар базаахгүй царайтай, удааширч

байгааг бригадын хоёр дарга амихандаа айхавтар сүрхий зөвшилцөж «хүнд» байдлаас гарахын тулд хөрөнгө хэмнэхээр шийдэж: «Эхнээсээ тооцох минь яалаа».

—Байгаа будгаараа хүртээж будъя.

Олзы нь хуваасан юм түргэлэхээс яахав гээд шуурхайлж гарчээ.

«Овсгоотой» засварчид нь багс «дэвхцүүлэн» будаг үсчүүлэн эрээлэхээс эхлээд «дотроо агаартай» шавардлага хүртэл олон «оновчтой» арга хэрэглэсний үрээр царман будагтай шал, дусаал хээтэй хаалга цонх олширч зарим өрөөний шал, будаг амсах хувь дутсан байна.

Хавар сууцаа засуулахаар гарсан айлууд гол ус мөхөөлөж ирсэн шувуу буцах тийшээ хандтал хүлээжээ.

Эл байдлыг үзсэн НААУГ-ын удирдах нөхд: Засварчдын зан цаашаа болж, эзэмшигчдийн ам наашаа боллоо.

Энэ 36 айлын сууцныг хүлээгээд авчихаас яахав гэж шийджээ.

За ингээд орон сууц эзэмшигчид ороод ирсэн чинь хананы пятаа нь хагархай хэвээрээ хаалга цонх нь хаагдаагүйг янзаараа... засварчдын сүүлд буцаагүй байхад зарим айлын пийшин, хананы шавар нураад иржээ.

Хэдэн жил наашаа харалтгүй гэж улсын хөрөнгө «урсгаж» хийсэн засварчид байхад түүнийг олон ширүүн үг дуулж сурсан ч гэлээ орон сууц эзэмшигчид энэ удаа хуваалцахгүй биз. Гадаад өнгөлгөө үлдсэн гэнэ, гайгүй шүү тав хоног гэлцээд НААУГ-тэргүүний засварчдаа шатгаж байхад зас-

ХАЙРАН ТЭЖЭЭЛ

Алтанбулаг сумын «Хөдөлмөр» нэгдлийн тариа бригад (дарга нь Бадарч) өнөө жил 948 га газар үр тариа, малын тэжээлийн ургамал тариалж ургац хураалтын ажлаа 9 дүгээр сарын 17-ноос эхлэн ажлын 12 хоногт 193 га талбайн ургацыг хадаж, 3300 боодол ногоон тэжээл бэлтгэснээс 1300 га-г нь нуруулджээ.

Саяхан аймгийн АХШ хороо, ХААУ Газраас хийсэн шалгалгаар ногоон тэжээлийг нойтноор нь боож нуруулсанаас 13,2 тонн ногоон тэжээл ялзарч малын тэжээлд тохирохгүй болсноос нэгдэлд 1896 төгрөгийн хохирол учирсны гадна талбайд боогоод орхисон 44,6 тонн ногоон тэжээл мөн халж муудах төлөвтэй болжээ. Газар тариалангийн үйлдвэрлэлийн технологийг зөрчиж хураалтын үед тавих хяналт шалгалтыг сулруулсан, улмаар эл байдлыг үзэхэд аймгийн удирдах нөхдөөс өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлээгүйгээс ийм байдалд хүрчээ.

Ер нь тус тариа бригад дээр ургац хураалтанд ажиллаж байгаа техникчдийн өдөр тутмын норм биелэгдэхгүй байгаа нь ажлын цаг ашиглалт муу, анхан шатны бүртгэл тооцоо хангалтгүй, хүмүүсийн

хариуцлага сул байгаатай холбоотой юм.

Тус бригад тариа хураалтанд туслахаар Улаанбаатар хотоос ирсэн хүмүүсийг 2 хоног шахам ажилгүй байлгасны гадна тус сумын дунд сургуулиас очиж ажиллаж байгаа сурагчдын хүчийг муу ашиглаж байхад сумын намын үүрийн нарийн бичгийн дарга Аюуш, нэгдлийн орлогч дарга Нямцэрэн, агрономч Л.Бадарч нар удаа дараалан очиж байсан атлаа зохион байгуулалтын шуурхай арга хэмжээ аваагүй өнгөрчээ.

Алтанбулаг сум-нэгдэл энэ дутагдалдаа дүгнэлт хийж одоо халах төлөвтэй байгаа 40 гаруй тонн ногоон тэжээлийг яаралтай задлан хатааж, хураалтын ажлыг шуурхайлан нэлсэн тариа хураах төхөөрөмжийг ажилд оруулж хаягдалгүй хураах цайруулах, мөн удаашралтай явагдаж байгаа цэвдэгш хагалгааны төлөвлөгөөг биелүүлэхэд бүх хүч бололцоог дайчлан ажиллах шаардлагатай байна.

Малдаа бэлтгэсэн тэжээлийг хаягдалгүй тээвэрлэж өвөлжөж, хаваржаанд татаж хашиж хамгаалахад нийт нэгдэл, САА-нууд шуурхай арга хэмжээ авч ажиллавал зохино.

Д. БУДРАГЧАА

бол. Юутай ч 80 гаруй мянган төгрөг зарж «их засвар» хийлгэсэн 36 айлын сууцаар тухтайхан орж «их засварчдынхаа» ажлыг эргэн үзгээд дүн өвлөөс наана дүнгий нь нарийвчлан гаргах болсон биш үү.

Манай тусгай сурталлагч Ш. ЦЭРЭНДОО

Улсын багш нарын зөвлөлгөөний өмнө

БАГШ НАРЫН МЭДЛЭГ БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛБЭ

Ерөнхий боловсролын сургуулиудын багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх талаар БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс гаргасан 176 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхээр Ардын Боловсролын Яамны Сайдын 1969 оны 221 тоот тушаалаар багш, хүмүүжүүлэгчдээс 6 нє дааж мэргэжлээ дээшлүүлэх программыг баталсан билээ.

Энэ программыг биелүүлэхийн тулд багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх аймгийн байнгын комиссыг 15 хүний бүрэлдэхүүнтэй, сумдад 5—7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж, багш, хүмүүжүүлэгч бүхэн 1—5 жилийн төлөвлөгөөтэй ажиллаж байна.

1972 оноос эхлэн сумдын комисс багш, хүмүүжүүлэгч нарыг 5 дугаар сарын сүүлч, 1 дүгээр сарын эхээр жилд 2 удаа шалгаж мэргэжлийн дэвэрт бичдэг боллоо.

Багш хүмүүжүүлэгч нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор унших номын нэрсийн жагсаалтыг гарган өгөх, заах аргын захидал бичих, семинар курст аль болохоор олон багш хүмүүжүүлэгчдийг хамруулан оролцуулах, жил болгон явагдах ээлжит сурган хүмүүжүүлэх уншлагад бүх багш, хүмүүжүүлэгч нарыг оролцуулах зорилтыг ардын боловсролын хэлтэс, сургалт заах аргын кабинет тавьж ирлээ.

1973 онд улсын хэмжээгээр явагдсан 11 төрлийн семинар курст 165 багш, хүмүүжүүлэгч явахаас 172 багш, хүмүүжүүлэгчдийг явуулж төлөвлөгөөг 104,2

хувиар биелүүлж, аймаг дээр 7 төрлийн семинарт 233 багшийг хамруулан оролцуулав.

Багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх талаар сургуулийн захиргаанаас зохиож байгаа ажлын талаар Баяндэлгэр сумын 8 жилийн дунд сургуулийн захирал Н.Мажигсүрэнгийн илтгэлийг захирлуудын зөвлөлгөөнөөр авч хэлэлцсэн бөгөөд 1973 онд төвийн 10 жил, Онжүүлгийн сургуулиудын хичээл хүмүүжлийн ажлыг шалган зааварлаж багш нараас шалгалт авлаа. Эдгээр ажлуудыг зохиож ирсний үр дүнд сургуулийн багш нараас биеэ дааж, мэдлэг боловсролоо дээшлүүлэх чухал хэлбэр болох сурган хүмүүжүүлэх уншлагад амжилттай оролцож ирэв.

1973 онд явагдсан сурган хүмүүжүүлэх II дахь шатны уншлагад 43 илтгэл, сургуулиудаас II дахь шатны уншлагад 10 илтгэлийг оруулан хэлэлцүүлснээс төвийн 10 жилийн дунд сургуулийн багш Галданцогт, Жаргалантын 10 жилийн дунд сургуулийн багш Санжаажамц нарын илтгэл улсад шалгарч байр эзэлсэн юм.

Мөн Баянчандманий 8 жилийн дунд сургуулийн ахмад багш Санжаажамц 4—5 дугаар ангийн монгол хэл бичгийн 60 гаруй сэдэв, Жаргалантын 10 жилийн дунд сургуулийн багш Санжаажамц 10 дугаар ангид жүжгийн зохиол бичих арга зүйг шинэ системийн программын дагуу боловсруулан сурган хүмүүжүүлэх хүрээлэнд бичиж боловсруулан өгсөн байна. 1974 онд

явагдсан сурган хүмүүжүүлэх II дахь шатны уншлагад 49 илтгэл шалгаран ирснийг аймгийн комиссоос дахин шалгаруулалт хийж 6 илтгэлийг II дахь шатны уншлагад орууллав.

Сурган хүмүүжүүлэх уншлагад орсон байдлыг авч үзвэл: Батсүмбэр, Баянзүрх, Баянчандмань, Дэлгэрхаан, Заамар, Мөнгөнморьт зэрэг сум-нэгдэл, сангийн аж ахуйн сургуулиудын багш нарын 90—100 хувь нь оролцсон байна. Гэтэл Борнуур, Лун, Эрдэнийн дунд сургуулиуд багш нарынхаа 15—30 хувийг оролцуулж, Баянцагаан, Баянжаргалан, Баян-өнжүүл, Баяндэлгэр, Угтаал, Бүрэнгийн дунд сургуулиуд ганц ч багш нарын илтгэл ирүүлээгүй байна.

Иймээс жил бүр явагдах ээлжит сурган хүмүүжүүлэх уншлагад багш хүмүүжүүлэгч бүр тодорхой сэдвээр оролцох хэрэгтэй байна.

Багш нараас илтгэл бичих дадлага чадвараа дээшлүүлэн дүгнэлт судлагаа сайтай бичиж байгаа зохино.

Мөн сургуулийн захиргаа, заах аргын нэгдлийн зөвлөлөөс багш нарын бичиж, боловсруулах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор сурган хүмүүжүүлэх ухаан, заах арга, сэтгэл судлал, шинжлэх ухаан техникийн ололт амжилт, сургууль дээр явагдаж байгаа хичээл, хүмүүжлийн ажлын явц зэргүүдийг илтгэл, лекц, туршлагын хэлбэрүүдээр бичүүлж байх нь зүйтэй.

Д.БУДРАГЧАА

СОРКО УГСААТАН

Нигерийн Бүгд Найрамдах улсын арал дээрх гол мөрнүүдийн хоорондуурх дал моднуудын сүүдэрт сүрлэн дээвэртэй бургасаар сүлжиж хийсэн 20—30-аад урц далдлагдаж байдаг юм.

Шовгор нарийн үзүүртэй урт онгоцнууд эрэгт татаатай байна.

Энэ бол Нигер мөрний эрэг орчмоор амьдардаг Сорко гэдэг угсаатны тосгон суурин ажээ.

Энэ багахан угсаатны бүхий л аж байдал нь гол мөрөн, загас агнууртэй салшгүй холбоотой. Сорко угсаатан бат бөх мод ухааж хөнгөн онгоцнууд дархлан хийдэг.



10 дугаар сард төвийн нутгаар сарын дундаж агаарын температур 0—4 градус, хэвийн хэмжээнээс 1—3 градусаар дулаан. Сарын шинэ дээр шөнөдөө 0—5 градус хүй-

тэн, өдөртөө 10—15 градус, сар шинийн эхээр зарим газраар 18—20 градус дулаан. Цаашдаа шөнөдөө 3—8 градус хүйтэн, 2 дугаар арав хоногийн дундуур ба сар хуучийн эцсээр хүйтэрч 8—13 градус хүрэх ба өдөртөө 8—13 градус, 2 дугаар арав хоногийн эхээр ба

сар хуучийн эцсээр 1—6 градус дулаан байна.

Хоногийн дундаж агаарын температур сар шинийн эцсээр 0 градусаас хүйтэн болно.

1—5 мм буюу хэвийн хэмжээнээс бага, зарим газраар хэвийн хэмжээний хур тунадас орно. Сар шинийн эхэн ба эц

ТА ЦАГАА ХЭДИЙД ТААРУУЛЖ БОЛОХ ВЭ

Хүн төрөлхтөн XVIII зууны үеэс эхлэн нарийн механизмтэй цаг хэрэглэх болжээ. 1550—иад онд цаг 2 зүүтэй болж улмаар 1760 оноос эхлэн секундийг хэмжих нарийн зүү бий болжээ.

Англи улсын нийслэл Лондон хотын Гринвичийн одон орон судлах газар 1912 оноос эхлэн цаг тааруулах дохиог тогтмол нэвтрүүлэх болсныг Гринвичийн цаг гэдэг. Одоо Москва хотын радио нэвтрүүлгийн 1 дүгээр прог-

раммаар цаг бүрийн эцэст (цаг тааруулах) дохиог 6 богино дохиогоор дамжуулдаг.

Үүний 6 дахь дохио нь цагийн 00 минут, 00 секундтэй яг тохирох учиртай. Манай улсын радиогийн 1 дүгээр программаар өглөө бүр 8 цагт Улаанбаатар хотын радио шугамаар нэвтрүүлдэг Зөвлөлтийн нэвтрүүлэг эхлэхэд уул дохиог сонсож цагаа тааруулж болно.

1974—1975 оны өвөл цагийн хүмүүжлийн ажлын цагийн хуваарь

ДАВАА

- | | |
|---------------------------------------|------------------|
| 1. Социалист хөдөлмөрийн сургууль | 19—21 цаг |
| 2. ХЗЭ-ийн улс төрийн сургууль | 19—21 цаг |
| 3. Ерөнхий боловсролын оройн сургууль | 19—23 цаг |
| 4. Орос хэлний оройн сургууль | бүлгэм 19—22 цаг |

МЯГМАР

- | | |
|--|------------------|
| 1. Төвийн намын үүрийн нарийн бичгийн дарга нарын ажил төрлийн семинар | 13—15 цаг |
| 2. Ахуй, соёлын сургууль (сар бүрийн 1,3 дугаар 7 хоног) | 19—21 цаг |
| 3. Иргэний хамгаалалтын сургууль (сар бүрийн 2,4 дүгээр 7 хоног) | 19—21 цаг |
| 4. Ерөнхий боловсролын оройн сургууль | 19—23 цаг |
| 5. Орос хэлний сургууль | бүлгэм 19—22 цаг |

ЛХАГВА

- | | |
|--|------------------|
| 1. Албан газрын дарга нарын ажил төрлийн семинар | 13—15 цаг |
| 2. Намын улс төрийн сургууль | 19—21 цаг |
| 3. Ерөнхий боловсролын оройн сургууль | 19—23 цаг |
| 4. Орос хэлний сургууль | бүлгэм 19—22 цаг |

ПҮРЭВ

- | | |
|---|-----------|
| 1. Нам, олон нийтийн байгууллагын хурал | 19—21 цаг |
| 2. Ерөнхий боловсролын оройн сургууль | 19—21 цаг |

БААСАН

- | | |
|---------|-----------|
| 1. Лекц | 19—21 цаг |
|---------|-----------|

БЯМБА

- | | |
|---------------------------------|--------------------------------------|
| 1. Улс төрийн сонгогч | 7 ³⁰ —8 ⁰⁰ цаг |
| 2. Үхуулагчдын сургууль семинар | 13—14 цаг |

ТАЙЛБАР: Биений тамир спортын төрөл бүрийн секцүүд, соёлын сургуулиуд Мягмар, Лхагва гаригт 19 цагаас, утга зохиолын дугуйлан аймгийн төвд Бямба гаригт 17 цагаас, зарим секцүүд Бямба, Нам гаригт хичээллэнэ.

Энэ цагийн хуваарийг 10 дугаар сарын 1—нээс 1975 оны 6 дугаар сарын 1 хүртэл аймгийн хэмжээгээр дагаж мөрдөнө.

Аймгийн Намын хорооны үзэл суртлын хэлтэс

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТӨВҮҮ

АРАВДУГААР САРД

тэн, өдөртөө 10—15 градус, сар шинийн эхээр зарим газраар 18—20 градус дулаан. Цаашдаа шөнөдөө 3—8 градус хүйтэн, 2 дугаар арав хоногийн дундуур ба сар хуучийн эцсээр хүйтэрч 8—13 градус хүрэх ба өдөртөө 8—13 градус, 2 дугаар арав хоногийн эхээр ба

сар хуучийн эцсээр 1—6 градус дулаан байна.

Хоногийн дундаж агаарын температур сар шинийн эцсээр 0 градусаас хүйтэн болно.

1—5 мм буюу хэвийн хэмжээнээс бага, зарим газраар хэвийн хэмжээний хур тунадас орно. Сар шинийн эхэн ба эц

сээр сар хуучийн дундуур солигдмол үүлтэй.

Зарим газраар бага зэргийн нойтон цас орно.

Бусад хугацаанд бага зэргийн үүлтэй. Хур тунадас орохгүй. Салхи ихэвчлэн баруун хойноос секундэд 3—7 метр байна. Сар шинийн ба 2 дугаар арав хоногийн эцэс сар хуучийн дундуур салхи секундэд 10—12 метр хүр

тэл ширүүсч зөөлөн шороон шуурга шуурна. 10 дугаар сард цаг агаарын байдал хөдөө аж ахуйд төдийлэн муу нөлөө үзүүлэхгүй боловч сарын эхний 10 хоногт төвийн нутгаар нилээд хур тунадас орж тариа ногоо цасанд дарагдах, чанарт нь муугаар нөлөөлж болзошгүй юм.

Аймгийн Ус Цаг уурын товчоо